



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 84

Мөрөн

“Иргэний боловсрол” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь :

1. “Иргэний боловсрол” аймгийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах боловсон хүчний болон санхүү, материалын нөөцийн асуудлыг аймаг, сумын төсөвт тусган шийдвэрлэж, эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны ажлыг бодитой, хүртээмжтэй, байнгын давтамжтайгаар зохион байгуулан, шалгуур үзүүлэлтийг хангаж, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг бүх сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Төрийн байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөг жил бүр батлан хэрэгжүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнгийн талаар Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурардаанд тайлагнаж ажиллахыг аймгийн /Засаг дарга/ А.Эрдэнэбаатарт үүрэг болгосугай.
4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж хэрэгжүүлэхийг аймгийн /Засаг дарга/ А.Эрдэнэбаатарт үүрэг болгосугай.
5. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн /ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга/ С.Цогтоод үүрэг болгосугай.

ДАРГА

Т.БОЛДБААТАР

D:\Тогтоол\Тэргүүлэгчдийн\11.20\иргэний боловсрол хөтөлбөр.docx

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны
11 дүгээр сарын 20-ны өдрийн
84 дүгээр тогтоолын хавсралт

**ЭРХ ЗҮЙН АЛБАН БУС СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ
“ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ” ХӨТӨЛБӨР**

Хөтөлбөрийн эрхэм зорилго

“Эрх зүйн соёлтой /мэдлэг, мэдээлэлтэй/, ёс зүйтэй иргэн”-ийг төлөвшүүлэх. Үүнд :

- Төрийн хууль тогтоомжийг дээдлэн сахиж, мөрддөг
- Нийгэм, гэр бүлийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг ухамсарласан
- Хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах чадвартай
- Хүний эрхийг хамгаалагч
- Үндэснийхээ түүх, соёл, уламжлалт зан үйлийг эрхэмлэн сахидаг, түгээн дэлгэрүүлэгч “Эрх зүйн соёл, ёс зүйтэй иргэн” гэж тодорхойлж байна. .

Хөтөлбөрийн зорилтууд

1. Иргэний эрх зүйн боловсролын орон нутгийн тогтолцоог боловсронгуй болгох
2. “Иргэний боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийг бүрдүүлэх
3. Эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааг оновчтой, хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах

**Иргэний эрх зүйн боловсролын орон нутгийн тогтолцоог
боловсронгуй болгох**

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцох талуудын чиг үүрэг нэлээд өргөн хүрээтэй байх төдийгүй хоорондоо нягт уялдаа холбоотой байна.

Дор дурьдсан байгууллага иргэдийн хамтын хүчин чармайлтаар энэ хөтөлбөр бүрэн хэрэгжих боломжтой юм. Тийм учраас иргэний эрх зүйн боловсролыг хөгжүүлэх орон нутгийн тогтолцоог дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд :

1. Аймаг, сумын ИТХурал, түүний Тэргүүлэгчид
2. Аймаг сумын Засаг дарга, түүний Тамгын газар
3. Хууль хяналтын байгууллагууд
4. Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөл
5. Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, ААНэгж
6. Боловсролын байгууллагууд
7. Хэвлэл мэдээллийн байгууллагууд

Аймаг, сумын ИТХурал, түүний Тэргүүлэгчид

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох аймаг, сумын ИТХурал болон түүний Тэргүүлэгчид нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрх зүйн бодит чадвартай дээр иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажлыг зохион байгуулж, хууль тогтоомж, хурлын шийдвэрийг тайлбарлан таниулах эрх үүргийг эдлэх тул эрх зүйн сургалт сурталчилгааны ажилд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэх, хурлын дэргэдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлыг эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны ажилтай уялдуулан зохион байгуулах чиглэлээр хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

Аймаг сумын Засаг дарга, түүний Тамгын газар

МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх, чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасны дагуу багийн Засаг дарга нар эрх зүйн албан бус сургалт сурталчилгаанд ашиглагдах иргэдийн өдөр тутмын амьдралд нэн чухал шаардлагатай байгаа ямар чиглэлийн мэдээлэл хэрэгцээтэй байгааг тодорхойлж, судалгаа гаргах, аймаг, сумын Засаг дарга нар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Хурал, Засаг даргын шийдвэрийг сурталчлах, биелэлтийг хангах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах чиг үүргийнхээ хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний болон санхүүгийн, материалын нөөцийг бүрдүүлэх, зохион байгуулахад бүхий л талаар дэмжлэг үзүүлэн оролцох, иргэдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсны үндсэн дээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны төлөвлөгөө”-г жил бүр батлан хэрэгжүүлж, хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг хариуцан ажиллана.

Аймгийн Хууль хяналтын байгууллагууд :

Аймгийн хэмжээнд гарч байгаа гэмт хэрэг зөрчил, шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны шалтгаан нөхцлийг судалж, бусад байгууллагад ашиглагдаж статистик мэдээллийг өгөх, төрийн болон төрийн бус байгууллага, ААН, иргэдэд эрхлэх асуудлын хүрээнд зөвлөмж, зөвлөгөө туслалцаа үзүүлэх, эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааг хамтран зохион байгуулах.

Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөл :

Төрийн албан хаагчдыг чадавхижуулах, төрийн албатай холбоотой маргааны статистик судалгааг гаргаж, төрийн байгууллагуудад зөвлөгөө, зөвлөмж өгч, төрийн албан хаагчдыг эрх зүйн чиглэлээр тусгайлсан мэдлэг мэдээлэлтэй болгох, салбар салбарын сургагч төрийн албан хаагчдыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэн сургагч төрийн албан хаагчдын баг бүрдүүлэх, албан хаагчдыг сургах, давтан сургах, ёс зүйтэй манлайлагч төрийн албан хаагчдыг нээн илрүүлэх, бусдад дууриал болгох уралдаант танин мэдэхүйн уралдааныг тэмцээнийг зохион явуулахад хамтран ажиллана.

Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, Аж ахуйн Нэгж

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрх зүйн сургалт сурталчилгааны нэвтрүүлэг бэлтгэн явуулах, иргэд, байгууллага болон зорилтот бүлгүүдэд чиглэсэн сургалт зохион байгуулах, ном, сэтгүүл, гарын авлага материал бэлтгэх, тараах, судалгаа хийх чиглэлээр төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны төсөл хөтөлбөрийг боловсруулан бие даан хэрэгжүүлж хамтран ажиллана.

Боловсролын байгууллагууд

“Иргэний боловсрол” хөтөлбөрийн хувьд Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан ёсоор Боловсрол, соёл шинжлэх ухааны яам Хууль зүйн яам хамтран боловсруулахаар туссан боловч уг хөтөлбөр одоог хүртэл батлагдан гараагүй байна. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт Иргэний боловсрол хичээл нь сургалтыг дэмжих үйл ажиллагаа цаг ба сурагчдыг хүнлэг, энэрэнгүй, ёс суртахуунлаг дадал хэвшилтэй монгол ёс заншил, соёлын үнэт зүйлийг эрхэмлэн хэрэглэдэг иргэн болгон төлөвшүүлэх, хүүхдүүдийн хичээлээр олж авсан мэдлэгийг амьдралд хэрэглэх арга зүйд суралцуулдаг.

Гэвч сургалтын хичээлийн хөтөлбөрт эрх зүйн мэдлэг мэдээллийг олгох чиглэлээр тусгай сэдэв, хөтөлбөр байхгүй байгаагаас хамаараад өсвөр үеийнхэнд чиглэсэн эрх зүйн системтэй боловсролыг олгож чадахгүй байна. Тиймээс эрх зүйн соёл, ёс зүйтэй иргэнд байх чадваруудыг хүүхэд ахуй цагаас нь олгох ажлыг аймгийн Боловсрол соёлын газар, ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран зохион байгуулна.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд

Орон нутгийн радио, телевиз, сонин нь иргэдийн мэдээллийг хүлээн авах чухал хэрэгсэл болж чадсан. Орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зайны сургалт, сэдэвчилсэн нэвтрүүлэг, сурталчилгааны ажлыг зохион байгуулах боломж нөхцөл бүрдэнэ.

“Иргэний эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийг бүрдүүлэх

Иргэний боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах нөөцийг бүрдүүлнэ. Үүнд :

1. Хүний нөөц

Эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж удирдах, гүйцэтгэх түвшний төрийн албан хаагчид, сургагч багш, эрх зүйн хөтчөөр эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны хүний нөөцийг бүрдүүлнэ. Хүний нөөцийг :

- **Зохион байгуулах чиг үүрэг бүхий хүний нөөц** – Эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны ажлын бодлого тодорхойлох түвшний төрийн удирдах албан тушаалтнууд хамаарна. Эрх зүйн албан бус сургалт

Сумдад 2013 оныг хүртлэх хугацааны хуулийн цахим санг цахим хэлбэрээр өгсөн боловч баяжуулалт хийж байгаа сум цөөн, хуулийн цаасан сан бүрэн бус, алдагдсан, дутсан, хөдөлгөөн хийдэггүй зэргээс шалтгаалаад мэдээлэл лавлагаанд ашиглах боломжгүй байгаа ба шилэн кабельд холбогдсон сум интернет ашиглаж хуулийн нэгдсэн сайтыг ашиглаж байна.

Ийм учраас эрх зүйн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, баг хамт олонд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, баг бүрт хуулийн цахим болон цаасан санг бүрдүүлэх, "Иргэний танхим"-уудыг 100 ашиглалттай байлгах ажлыг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай.

Эрх зүйн албан бус сургалтыг оновчтой, хүртээмжтэй зохион байгуулж, үр дүн гаргах

9. Эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны ажлыг 3 түвшинд зохион байгуулна. Үүнд :

❖ **Төрийн албан хаагчдын түвшинд :** Төрийн албан хаагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, салбарын хууль тогтоомжоос гадна шинээр батлагдаж буй хууль, хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүдийг үйл ажиллагаанд ашиглах, мэдээллийг ажиллаж амьдарч буй орчин тойрондоо түгээх, иргэдэд эрх зүйн сургалт, сурталчилгаа хийх, хуулийн талаар зөвлөгөө тусалцаа үзүүлэх арга зүйд суралцуулж, эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.

❖ **Иргэд, ААН байгууллагын түвшинд :** Иргэдэд хууль сурталчлан таниулах нэгдсэн төлөвлөгөөг бүх төрийн байгууллагуудад хүргүүлж, биелэлтийг тооцон хяналт тавин ажиллахын зэрэгцээ иргэдийн мэдээлэл олж авч буй мэдээллийн сувгуудыг ашиглан зорилтот нэвтрүүлгүүдийг бэлтгэн явуулах, сургалт сурталчилгааны уламжлалт арга хэлбэрийг шинэлэг арга хэлбэртэй хослуулан ашиглаж мэдээ мэдээллийг түгээх арга хэмжээг зохион байгуулна.

❖ **Хүүхэд, өсвөр үе, залуучуудын түвшинд :** Хүүхэд, өсвөр үе залуучуудад чиглэсэн сургалтын сэдвүүдийг нэгдсэн төлөвлөгөөнд оруулан батлуулж, нас сэтгэхүй, онцлогт нь тохирсон сургалтуудыг сургагч багш нар болон төрийн албан хаагчдаар хийлгэх, нийтлэг гарч буй алдаа дутагдал, түүнээс урьдчилан сэргийлэх, хүндрэлтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга зам, гарцыг зааж, уламжлал, өв соёлоороо бахархах зөв үзэл хандлага, дадал хэвшлийг суулгах чиглэлээр бусад байгууллагуудтай хамтран ажиллана.

10. "Иргэний боловсрол" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын агуулга, арга хэлбэр

Эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны ажлын агуулга хамрах хүрээ

❖ Монгол улсын хууль, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, Яамдын сайд, агентлагийн дарга нарын хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт, аймгийн Засаг даргын болон ИТХ-ын шийдвэрүүд

- ❖ Олон улсын гэрээ, конвенц, тунхаглал, Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ
- ❖ Хууль тогтоомжийг амьдралд хэрхэн дагаж мөрдөх, хэрэглэх асуудлууд
- ❖ Монголчуудын хууль дээдлэх ёсны уламжлал, зан заншлын уг сурвалжууд

Эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны ажлын зарчим

- ❖ Энгийн
- ❖ Ойлгомжтой
- ❖ Хүртээмжтэй
- ❖ Хамтын оролцоотой
- ❖ Шуурхай
- ❖ Байнгын тасралгүй, системтэй байх

Эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны ажлын хэлбэрүүд

- ❖ Сургалт
- ❖ Уулзалт, ярилцлага, асуулт хариулт
- ❖ Сэдэвчилсэн уралдаан тэмцээн
- ❖ Театрчилсан тоглолт
- ❖ Радио телевизийн нэвтрүүлэг
- ❖ Иргэний танхимыг үйлчилгээ, явуулын иргэний танхим ажиллуулах
- ❖ Лекц семинар

11. “Иргэний боловсрол” хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа

А. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, албан тушаалтны үүрэг оролцоог сайжруулах

1. “Иргэний боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн нэгдсэн төлөвлөгөөг жил бүр гаргах ба сум, байгууллагууд нэгдсэн төлөвлөгөөнд туссан хариуцсан ажлуудыг чанартай үр дүнтэй хэрэгжүүлэх

2. Сумд сургалт сурталчилгаа зохион байгуулах нэгдсэн багийг мэргэшсэн албан хаагчдаар бүрдүүлэх, байгууллагууд сургалт, мэдээллийн ажил хариуцах ажилтны эрх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, эрх зүйн актаар баталгаажуулах. Сургалт сурталчилгаа хариуцсан ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтад хамруулах, үйл ажиллагаандаа шинэлэг ажлыг нэвтрүүлэхэд тус дөхөм үзүүлж туршлага судлуулах, үр дүнтэй ажиллуулах

3. Сургалт сурталчилгааны ажилд төрийн бус байгууллагууд иргэдийг өргөнөөр татан оролцуулах шинэлэг арга хэлбэрийг ажлуудыг нэвтрүүлэх, бусдад туршлага болгох

Б. Хууль эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлын хуучин арга хэлбэрийг шинэчлэх, боловсронгуй болгох арга замыг тодорхойлох

1. Иргэдийн хэрэгцээ шаардлагыг тодохойлох. Бодит хэрэгцээнд тулгуурласан мэдээллийг иргэдэд өгч, мэдээлэл хийгээд хэрэгцээ шаардлага 2-ын холбоог байнга судлах

2. Иргэдийн мэдээлэл авахыг хүсч буй мэдээллийн хэрэгслийг ашиглан мэдээллийг түгээх. Үүний тулд мэдээлэл түгээх санхүүгийн эх үүсвэрийг бүрэн шийдвэрлэж өгөх

В. Сургалт явуулахад шаардлагатай материаллаг бааз, хэрэглэгдэхүүнтэй болох

1. Сумдын "Иргэний танхим"-уудыг байнгын ажиллагаатай байлгаж, төрийн үйлчилгээг иргэнд шууд хүргэх
2. Хуулийн цаасан болон цахим санг сум, баг байгууллагуудад бий болгож, ашигладаг болох
3. Эрх зүйн сургалт, сурталчилгааны төсвийг тусгайлан тусгаж шийдвэрлэдэг болох
4. Суманд радио, телевиз ашиглан сургалт, сурталчилгаа зохион байгуулах нөхцөл боломжийг бий болгох

Г. Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, тэдний эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх

1. Жил бүр сумдын ЗДТГ-ын дарга болон дотоод ажил, эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, байгууллагын сургалт сурталчилгаа хариуцсан ажилтан, эрх зүйн хөтөч, сургалт сурталчилгааны багийн гишүүдэд сургалт зохион байгуулах
2. Төрийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх олимпиадыг байгууллага, сум тус бүр зохион байгуулж, шалгарсан албан хаагчдын нэгдсэн уралдааныг аймгийн төрийн албаны салбар зөвлөл зохион байгуулж, түрүүлсэн 1 албан хаагчийг хуулийн чиглэлээр мэргэшүүлэх суралцах боломж нөхцлөөр хангах

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2016-2018 онд 3 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

Аймаг, сум, байгууллагын хэмжээнд эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны нэгдсэн тогтолцоо бүрдэж, байнгын, тогтмол, үр дүнтэй үйл ажиллагаа явагдаж хэвшсэнээр төрийн албан хаагчид, иргэдийн эрх зүйн соёл, мэдлэг ухамсар дээшил, нийт хүн амын 60-70 хувь нь эрх зүйн албан бус сургалт, сурталчилгаанд хамрагдаж, эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны ажлын үзүүлэлт хүрэх ёстой түвшиний 80-90 хувьд хүрвэл "Иргэний боловсрол" хөтөлбөрийн зорилго, зорилт биелэсэн гэж үзнэ.

**Эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны ажлын
аймгийн дундаж үзүүлэлт ба хүрэх түвшин**

№	Зохион байгуулах арга хэмжээ		Аймгийн дундаж	Хүрэх түвшин
1	Эрх зүйн албан бус сургалт сурталчилгааг сум бүр улиралд зохион байгуулах давтамж	Сум	1-2	6
	Эрх зүйн сургалтын цаг \улиралд\		4	12
	Эрх зүйн албан бус сургалтын иргэдийн оролцоо жилд		20-30 %	50-70%
2	Төрийн албан хаагчдад эрх зүйн албан бус сургалт сурталчилгааг улиралд зохион байгуулах давтамж	Төрийн байгууллага	1-2	12
	Эрх зүйн сургалтын цаг \улиралд\		4	12
	Эрх зүйн албан бус сургалтад байгууллагын албан хаагчдын оролцоо\ жилд\		40-60 %	90 %
3	Хүүхэд, өсвөр үе, залуучуудад хийгдэх сургалтын давтамж \жилд\		1-2	6
	Оролцоо \хүүхэд, өсвөр үе, залуучууд тус бүрээр\		10-20	50-70%
4	Телевизийн нэвтрүүлгээр улиралд нэвтрүүлэх давтамж	Сум	0-1	3
	Нийт цаг		30 мин	1.5 цаг
5	Телевизийн нэвтрүүлгээр улиралд нэвтрүүлэх давтамж	байгууллага	1	2
	Нийт цаг		20 мин	1 цаг
6	Орон нутгийн радиогоор нэвтрүүлэг хийх давтамж \жилд\	Сум, байгууллага		12 цаг
	Нийт цаг			6 цаг
7	Байгууллага бүр мэдээллийн самбарыг шинэчлэх давтамж \жилд\		4	12
8	Орон нутгийн сонин хэвлэлд сурталчилгааны материал нийтлүүлэх \жилд \	Сум, байгууллага	1	4
9	Сумын эрх зүйн мэдээллийн цахим болон цаасан санг бүрдүүлэх, санг иргэдэд ашиглуулах боломж нөхцлийг хангах	Сум	40-50%	80-90%
10	Иргэний танхимыг түшиглэж хууль эрх зүйн зөвлөгөө туслалцаа үзүүлэх, мэдээлэл олгох бааз суурийг бий болгох	Сум	20-30%	80-90
11	Вэб сайтад хууль тогтоомжийн талаарх сурталчилгаа, мэдээллийг тогтмол тавьж, шинэчлэн ажиллах	Сум, байгууллага		2 долоо хоног тутамд 1 удаа